



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020. 03. 18 № 05

Г Асуулга тавих тухай Г

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна.

Коронавирусийн эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн бодит байдлыг үнэлж, учрах эрсдэлийг бууруулах хүрээнд Засгийн газар, Монголбанкнаас хамтран ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаар дараах байдлаар танилцуулж, мэдээлэл ирүүлнэ ўу. Үүнд:

1. Эдийн засаг, нийгэм, санхүүгийн салбарт үзүүлж болзошгүй нөлөөллийн тооцоолол;

2. Төсвийн орлого, зарлага, санхүүжилт, төлбөрийн тэнцэл, валютын нөөц, инфляци, ханш, санхүүгийн тогтвортой байдал, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх сөрөг үр дагавар, дүгнэлт;

3. Нөлөөллийг саармагжуулах ерөнхий төлөвлөгөө;

4. Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрхийн болон хувийн хэвшлийн ажлын байрыг хамгаалах, нийгмийн давхарга бурд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд (тооцооллын хамт);

5. Төсвийн орлого буурч байгаагаас үүдэн зарлагын төлөвлөсөн хэмжээг бууруулах шаардлагатай ч Сангийн сайдын мэдэгдсэнээр төсвийн тодотгол хийхгүй тохиолдолд алдагдлыг хэрхэн санхүүжүүлэх, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн талаар олон улсын байгууллагууд, хөгжлийн түншүүдтэй аливаа яриа хэлэлцээ хийж байгаа бол энэ талаарх мэдээлэл;

6. Арилжааны банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрийн байдал (өртөг зардлын байдал), өөрийн хөрөнгийн дутагдлын талаарх мэдээлэл;

7. УИХ-аас яаралтай хэлэлцэн батлах хууль, тогтоолын төслүүд зэрэг болно.

2020000020

Асуулгын хариуг УИХ-ын чуулганы цахим хуралдаанд танилцуулж, эрсдэлийн эсрэг авч буй арга хэмжээ, улсын төсвийн талаар баримталж буй бодлого болон бусад бодлогын дэмжлэгийн талаар нээлттэй мэдээлж, хэлэлцэх шаардлагатай байгааг анхаарна уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

ЗНАРАНТУЯА



2020000020